



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/652

Хэрлэн сум

Түүх, соёлын хөдлөх дурсгалт
зүйлийн тооллогыг зохион байгуулж,
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.1.1, 16.1.5, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 184 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх журам”-ын 2.2 дэх хэсэг, Соёлын сайдын 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдрийн “Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллого хийх тухай” А/317 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн хэмжээний нутаг дэвсгэрийн төрийн болон орон нутгийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг 2024 оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулсугай.

2. Тооллогыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга:	Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Өнөрбаяр	Аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч
Гишүүд:	Л.Бүрэнтөгс	Соёл, урлагийн газрын Соёлын өвийн асуудал хариуцсан мэргэжилтэн
	Б.Төгсжаргал	Аймгийн музейн Эрдэм шинжилгээний ажилтан
	Ш.Цогт-Очир	Аймгийн музейн Цахим мэдээлэл, харилцаа холбооны ажилтан

3. Тооллогын ажлыг холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу зохион байгуулж, нэгдсэн дүн, цаашид авах арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг ажлын хэсгийн дарга (Т.Зулбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ